



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

Статистикийн танилцуулга

2017/6



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2015-2017 ОН	3
 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	4
 ДҮҮРГИЙН ТӨСӨВ	7
 АЖ ҮЙЛДВЭР	9
 ХӨДӨӨ АЖ АХУЙ	11
 ГАЗАР ТАРИАЛАН	12
 ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ	13
 МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО	13
 НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	14
 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	14
 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	16
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	17
 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	18
 ГЭМТ ХЭРЭГ	19
ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ	21

ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Жил бүрийн эхний 6 сарын байдлаар


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015 он	2016 он	2017 он
Суурин хүн ам, сарын эцэст	хүн	140233	152813	161280
Шинээр төрсөн хүүхэд	тоо	2178	2196	2147
Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	1885	1687	737
Үүнээс: эмэгтэй	хүн	943	922	367
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	1977	2404	1452
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	726	871	728
Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт	хувь	0.1	-0.5	0.7
Валютын зах зээлийн ханш, сарын эцэст	1US\$ =₮	1963.5	1982.2	2349.9
Дүүргийн төсвийн орлого	сая.төг	26475.7	29642.0	29593.4
Дүүргийн төсвийн зарлага	сая.төг	22036.5	23895.2	25236.2



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны 6-р сарын хэрэглээний үнийн индекс 2016 оны мөн үетэй харьцуулахад 3.4 хувиар, 2016 оны эцэстэй харьцуулахад 4.6 хувиар тус тус өсч, харин өмнөх сартай харьцуулахад 0.7 хувиар буурсан байна.

Зураг 1. Хэрэглээний үнийн индекс, 2015-2017 он



Хэрэглээний үнийн индекс 2017 оны 6-р сард өмнөх оны эцэстэй харьцуулахад 4.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 10.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 2.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.0 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 1.4 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 3.2 хувь, тээврийн үйлчилгээ 8.9 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ 0.5 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 2.5 хувь, бусад бараа, үйлчилгээ 3.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 1. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2016-06</u> 2015-06	<u>2017-06</u> 2016-06	<u>2017-06</u> 2016-12	<u>2017-06</u> 2017-05
Ерөнхий индекс	101.2	103.4	104.6	99.3
Хүнсний бараа, ундаа, ус	97.5	100.7	110.7	97.1
Согтууруулах ундаа, тамхи	103.2	102.2	102.1	100.7
Хувцас, бөс бараа, гутал	100.7	102.1	101.0	100.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	98.0	104.2	98.8	99.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	101.9	102.6	101.4	99.9
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	109.9	105.9	103.2	99.8
Тээвэр	97.9	111.2	108.9	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.4	100.1	100.5	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	101.2	100.4	102.5	100.4
Боловсролын үйлчилгээ	123.6	101.8	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	101.6	100.9	99.6	101.9
Бусад бараа, үйлчилгээ	102.3	106.7	103.9	100.4

2017 оны 6-р сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 18.6 хувийнх нь үнэ өсч, 21.5 хувийнх нь үнэ буурч, 59.9 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байлаа.

Хүснэгт 2. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекст нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	-2.9	Энэ бүлгийн бууралтад талх, гурил, будаа 0.3 хувиар, махан бүтээгдэхүүн 6.2 хувиар, хүнсний ногоо 3.8 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.
Согтууруулах ундаа, тамхи	0.7	Согтууруулах ундаа, тамхины бүлгийн өсөлтөд дарс 2.8 хувиар, шар айраг 1.6 хувиар өссөн нь нөлөөлөв.
Хувцас, бөс бараа, гутал	0.2	Энэ бүлгийн өсөлтөд бүх төрлийн хувцас 0.1 хувиар, бүх төрлийн гутал 0.2 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Орон сууц, ус, цахилгаан, түлш	-0.9	Энэ бүлгийн бууралтад сууц хөлслөгчийн төлсөн бодит түрээс 9.1 хувиар буурсан нь нөлөөлжээ.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	-0.1	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн бууралтад гэрийн тавилга, хэрэгсэл 0.4 хувиар, гэр ахуйн цахилгаан бараа 0.8 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	-0.2	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн бууралт нь эм, тариа 0.5 хувиар буурсантай холбоотой байв.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.4	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн өсөлтөд соёл, амралтанд зориулсан бусад хэрэгсэл 3.8 хувиар, чөлөөт цагт зориулсан бусад хэрэгсэл 3.8 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	1.9	Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны бүлгийн өсөлтөд нийтийн хоолны үйлчилгээ 2.0 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Бусад бараа, үйлчилгээ	0.4	Бусад бараа, үйлчилгээний өсөлт нь гоо сайхны хэрэгцээнд зориулсан бусад эд зүйлс 0.9 хувиар өссөнөөс шалтгаалжээ.

Эх үүсвэр: “Нийслэлийн нийгэм, эдийн засгийн байдал” статистикийн 2017 оны 6-р сарын танилцуулга

2017 оны 6-р сарын 28-ны өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад элсэн чихэр 700 төгрөг, цагаан будаа 100 төгрөг, задгай сүү 100 төгрөг, “Сүү” ХК-ны цөцгийтэй тараг 370 төгрөгөөр тус тус өссөн байхад хонины мах 1100 төгрөг, үхрийн мах 200 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн дээд зэргийн гурил 90 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 1-р зэргийн гурил 100 төгрөг, төмс 500 төгрөг, байцаа 400 төгрөг, лууван 1200 төгрөг, манжин 300 төгрөг, сонгино 100 төгрөг, фүжи алим 600 төгрөгөөр тус тус буурсан байна. Харин “Алтан тариа” ХК-ийн 2-р зэргийн гурил, “Талх чихэр” ХК-ны Атар талхны үнэ тогтвортой байлаа.

Хүснэгт 3. Хүнсний өргөн хэрэглээний барааны дундаж үнэ*, жил бүрийн 6-р сарын байдлаар


№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2016.06	2017.06	$\frac{2017}{2016}$ %
1	Талх “Атар”, “Талх чихэр” ХК	Ширхэг	1160	1160	100.0
2	Хонины мах, ястай	Кг	6600	5500	83.3
3	Үхрийн мах, ястай	Кг	8200	8000	97.6
4	Гурил , дээд зэрэг, “Алтан тариа”	Кг	1400	1310	93.6
5	Гурил ,1-р зэрэг, “Алтан тариа”	Кг	1170	1070	91.5
6	Гурил ,2-р зэрэг, “Алтан тариа”	Кг	900	900	100.0
7	Элсэн чихэр	Кг	1600	2300	143.8
8	Төмс, монгол	Кг	1200	700	58.3
9	Байцаа, монгол	Кг	1600	1200	75.0
10	Лууван, монгол	Кг	2000	800	40.0
11	Манжин, монгол	Кг	1800	1500	83.3
12	Сонгино, хятад	Кг	1600	1500	93.8
13	Цагаан будаа	Кг	2300	2400	104.3
14	Алим, фүжи	Кг	4500	3900	86.7
15	Сүү, задгай	литр	1200	1300	108.3
16	Тараг, цөцгийтэй, “Сүү ” ХК	литр	2160	2530	117.1

*- Худалдаа үйлчилгээний “Мөнхсүврага” төв


Зураг 2. Нэг кг махны дундаж үнэ, төгрөг



Зураг 3. Нэг кг гурилын дундаж үнэ, төгрөг



Зураг 4. Нэг кг төмс, лууван, байцааны дундаж үнэ, төгрөг



Зураг 5. Нэг кг манжин, сонгины дундаж үнэ, төгрөг



Хүснэгт 4. Нэг литр шатахууны үнэ, 2017.06.28-ний байдлаар, төгрөг

ШТС	2016.06.30					2017.06.28				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	1750	1470	1530	1640		1820				
Петровис	1750		1530	1640		1820	1480	1630	1720	
Магнай трейд	1750	1470	1530	1640		1820	1480	1630	1720	
Сод монгол	1750		1530	1640		1820				
Шунхлай		1470	1530	1640				1630	1720	
Юнигаз					900					1050
Дундаж үнэ	1750	1470	1530	1640	900	1820	1480	1630	1720	1050


Эх үүсвэр: “Нийслэлийн нийгэм, эдийн засгийн байдал” статистикийн 2017 оны 6-р сарын танилцуулга



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

2017 оны эхний 6 сард дүүргийн орон нутгийн төсвийн орлого 29.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 1.2 тэрбум төгрөгөөр буюу 4.0 хувиар тасарсан байна.

Зураг 6. Төсвийн орлого, зарлага, 2011-2017 он, сая төг



Төсвийн нийт орлогын 25.6 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 5.4 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого), 69.0 хувийг улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна.

Хүснэгт 5. Дүүргийн төсвийн орлого, оны эхний 6 сард сая.төг


	Төсвийн орлого			Үүнээс:								
	Бүгд	ТБ %	Зөрүү сая. төг	Татварын орлого			Татварын бус орлого			Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн орлого		
				Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг
Дүн	29593.4	96.0	-1219.8	7571.9	84.1	-1435.3	1611.1	115.4	215.6	20410.4	100	0

Татварын орлогын хэмжээ 7.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 1.4 тэрбум төгрөгөөр буюу 15.9 хувиар тасарсан байна. Харин татварын бус орлого 1.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 215.6 сая төгрөгөөр буюу 15.4 хувиар давж биелэсэн байна.

Бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 1.5 тэрбум төгрөгөөр тасарсан бол орлогын албан татвар төлөвлөснөөс 103.7 сая төгрөгөөр, хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 2.0 сая төгрөгөөр тус тус илүү бүрджээ.

Татварын бус орлогын 70.3 хувийг торгуулийн орлого, 29.7 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого болон бусад орлого, татварын орлогын 60.6 хувийг орлогын албан татвар, 39.4 хувийг хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж тус тус эзэлж байна.

Зураг 7. Татварын орлогын бүтэц, хувиар



Зураг 8. Татварын бус орлогын бүтэц, хувиар



Хүснэгт 6. Дүүргийн төсвийн орлого, оны эхний 6 сард сая.төг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ, %	Зөрүү
Орон нутгийн орлого	30813.1	29593.4	96.0	-1219.8
1.Татварын орлогын дүн	9007.2	7571.9	84.1	-1435.3
1.1 Орлогын албан татвар	4486.5	4590.2	102.3	103.7
Хувь хүний орлогын албан татвар	4486.5	4590.2	102.3	103.7
1.2 Хөрөнгийн албан татвар	17.7	19.8	111.5	2.0
1.3 Бусад татвар, төлбөр, хураамж	4503.0	2961.8	65.8	-1541.1
Улсын тэмдэгтийн хураамж	3823.5	1955.9	51.2	-1867.6
Ашигт малтмал ашигласны төлбөр	19.5	11.3	58.1	-8.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	660.0	994.7	150.7	334.6
2.Татварын бус орлогын дүн	1395.5	1611.1	115.4	215.6
Төсөвт байгууллагын өөрийн орлого	560.7	428.8	76.5	-131.9
Торгуулийн орлого	794.8	1132.9	142.5	338.2
Бусад орлого	40.0	49.4	123.3	9.3
3. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	20410.4	20410.4	100.0	0.0
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	20291.9	20291.9	100.0	0.0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	118.5	118.5	100.0	0.0

2017 оны эхний 6 сард орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 80.3 хувийг буюу 25.2 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 19.7 хувийг буюу 6.2 тэрбум төгрөгийг төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Төсвийн нийт зарлагын 48.1 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 5.3 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 4.6 хувийг татаас болон урсгал шилжүүлэг, 42.0 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 7. Дүүргийн төсвийн орлого, зарлага, оны эхний 6 сард сая.төг

	Орлого	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Нийт дүн	29593.4	31413.1	25236.2	80.3	-6177.0	4357.2

Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн сарын эхэнд 106.3 сая төгрөгийн өглөгтэй байсан бөгөөд 44.4 сая төгрөгийн өглөг шинээр үүсч, 80.3 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, сарын эцэст нийт 70.4 сая төгрөгийн өглөгтэй болсон байна.

Хүснэгт 8. Өглөг, оны эхний 6 сард, сая.төг

	6-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	6-р сарын эцсийн үлдэгдэл
Нийт дүн	106.3	44.4	80.3	70.4

АЖ ҮЙЛДВЭР




Дүүргийн аж үйлдвэрийн газрууд оны эхний 6 сард 409.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 365.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 8.2 хувиар, борлуулалт 16.1 хувиар тус тус өссөн байна.

Зураг 9. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлт, борлуулалт, 2016-2017 оны сар бүрээр, тэрбум төгрөг




Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 301.8 тэрбум төгрөгийг дотоодод, 63.9 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 17.5 хувийг экспортод гаргасан бөгөөд нийт экспортын 86.1 хувийг ноос, ноолуур, нэхмэлийн үйлдвэрлэлт, 11.5 хувийг арьс ширний үйлдвэрлэлт, 1.0 хувийг ундаа үйлдвэрлэлт, 0.7 хувийг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 0.7 хувийг бусад ашигт малтмал олборлолт тус тус эзэлж байна.

Зураг 10. Үйлдвэрлэлт, 2015-2017 он, тэрбум төг



Зураг 11. Борлуулалт, 2015-2017 он, тэрбум төг



Хүснэгт 9. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/

Салбараар	Нийт бүтээгдэхүүн		
	2016 он I-VI сар	2017 он I-VI сар	$\frac{2017}{2016}$ %
Уул уурхай олборлох үйлдвэр	2966.1	2359.1	79.5
Төмрийн хүдэр олборлолт	2557.4	1890.0	73.9
Бусад ашигт малтмал олборлолт	408.7	469.1	114.8
Боловсруулах үйлдвэр	318958.5	349712.2	109.6
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	165480.7	162055.3	97.9
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	2721.8	1009.4	37.1
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1089.8	8391.7	7.7*
Хүнсний бусад бүтээгдэхүүн	12309.9	16993.9	138.1
Ундаа үйлдвэрлэл	149359.2	135660.3	90.8
Нэхмэлийн үйлдвэрлэлт	118981.5	132135.9	111.1
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	956.2	1344.2	140.6
Арьс шир боловсруулах үйлдвэр	4794.9	8131.7	1.7*
Мод, модон эдлэл	1486.4	3145.9	2.1*
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2643.4	4498.8	1.7*
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	3055.9	3131.3	102.5
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	16131.4	28868.5	1.8*
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	3385.0	3373.8	99.7
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	1221.4	1945.5	1.6*
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	55.1	79.4	144.1
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	13.8	93.5	6.8*
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	597.2	721.3	120.8
Мебель тавилга үйлдвэрлэл	155.6	187.1	120.2
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	56248.3	57051.4	101.4
ДҮН	378172.9	409122.7	108.2

*-дахин

Хүснэгт 10. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/

Салбараар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2016 он I-VI сар	2017 он I-VI сар	$\frac{2017}{2016}$ %	үүнээс: экспорт, %
Уул уурхай олборлох үйлдвэр	2966.1	2359.1	79.5	0.1
Төмрийн хүдэр олборлолт	2557.4	1890.0	73.9	-
Бусад ашигт малтмал олборлолт	408.7	469.1	114.8	100.0
Боловсруулах үйлдвэр	255652.8	306304.0	119.8	20.7
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	135110.2	159884.5	118.3	0.7
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	3376.3	1009.4	29.9	45.3
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1275.6	8616.0	6.7*	
Хүнсний бусад бүтээгдэхүүн	11845.8	16337.4	137.9	
Ундаа үйлдвэрлэл	118612.5	133921.7	112.9	0.5
Нэхмэлийн үйлдвэрлэлт	84686.1	90218.1	106.5	61.0
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	819.7	1373.9	1.7*	
Арьс шир боловсруулах үйлдвэр	4839.1	8143.8	1.7*	90.0
Мод, модон эдлэл	1486.4	3145.9	2.1*	
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2640.0	4498.8	1.7*	
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	3500.5	3785.5	108.1	
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	17086.6	28550.0	1.7*	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	3385.0	3477.6	102.7	
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	1229.6	1958.7	1.6*	
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	53.9	79.4	147.3	
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	54.2	93.5	1.7*	
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	605.9	907.2	149.7	
Мебель тавилга үйлдвэрлэл	155.6	187.1	120.2	
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	56248.3	57051.4	101.4	
ДҮН	314867.2	365714.5	116.1	17.5

*-дахин



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Дүүргийн хэмжээнд 2017 оны эхний 6 сард 11062 хээлтэгч мал төллөжээ. Нийт төллөсөн 11069 төлийн 213 нь хоргодож, 10856 төл бойжиж байна. Төл бойжилт 98.1 хувьтай байна.

Хүснэгт 11.Төл бойжилт, төрлөөр, жил бүрийн эхний 6 сард


Үзүүлэлт	2016.06	2017.06	Үүнээс:				
			Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Төллөсөн хээлтэгч мал	7604	11062	-	776	3241	3746	3299
Гарсан төл	7604	11069	-	776	3241	3748	3304
Үүнээс:							
Хорогдсон төл	71	213	-	49	44	53	67
Бойжсон төл	7533	10856	-	727	3197	3695	3237
Бойжилтын хувь	99.1	98.1	-	93.7	98.6	98.6	98.0

Бойжсон нийт төлийн 6.7 хувийг унага, 29.4 хувийг тугал, 34.0 хувийг хурга, 29.9 хувийг ишиг эзэлж байна.

Хүснэгт 12. Том малын зүй бус хорогдол, жил бүрийн эхний 6 сард

Үзүүлэлт	2016.06	2017.06	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал	195	683	-	80	118	259	226
Үүнээс: Өвчнөөр хорогдсон	2	24	-	3	17	2	2
Хорогдсон хээлтэгч	182	213	-	12	29	88	84

Зураг 12. Том малын зүй бус хорогдол, төрлөөр




ГАЗАР ТАРИАЛАН

2017 оны эхний 6 сард дүүргийн хэмжээнд 24 га талбайд төмс, 119.8 га талбайд хүнсний ногоо тариалжээ. Тариалалтын мэдээгээр нийт 143.8 га нь усалгаатай талбай байна.

Хүснэгт 13. Тариалсан талбай, 6-р сар

Үзүүлэлт	2016.06	2017.06	Өсөлт бууралт /хувиар/
Төмс	38	24	-36.8
Хүнсний ногоо	48.5	119.8	1.4*
Байцаа	17	87.4	4.1*
Лууван	5.5	12.5	1.3*
Шар манжин	4	6.8	70.0
Улаан манжин	3	3.2	6.6
Сонгино	2.5	2.9	16.0
Сармис	-	0.7	-
Өргөст хэмх	13	3.4	-73.8
Улаан лооль	2.5	1.9	-24.0
Чинжүү	1	-	-
Бусад	-	1.0	-

Зураг 13. Тариалсан талбай, 6-р сарын байдлаар





ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны 2-р улиралд Дүүргийн тохижилт үйлчилгээний төв хог цэвэрлэгээний ажлаар 518.4 мян.м2 зам талбайг цэвэрлэж, нийт 31.1 мянган тонн хог тээвэрлэсэн байна. Тээвэрлэсэн нийт хогны 18.1 хувийг орон сууцнаас, 40.4 хувийг гэр хорооллоос, 41.3 хувийг аж ахуйн нэгж байгууллагаас, 0.2 хувийг зам талбайгаас тээвэрлэсэн хог эзэлж байна.

Оны эхний 6 сард дүүргийн хог цэвэрлэгээний ажилд зарцуулсан хөрөнгийн 259.2 сая төгрөгийг зам талбай цэвэрлэсэнд, 1.3 тэрбум төгрөгийг хог тээвэрлэхэд зарцуулжээ.

Хүснэгт 14. Хог цэвэрлэгээний ажил, зарцуулсан хөрөнгө, 2017 оны 2-р улиралд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		Зарцуулсан хөрөнгө сая. төг	
		2016.II	2017.II	2016.II	2017.II
Цэвэрлэсэн зам талбай	мян м2	773.9	518.4	208.0	259.2
Тээвэрлэсэн хог	тн	30387.9	31140.5	1395.2	1274.7
Үүнээс: Орон сууцнаас	тн	5933.8	5644.8	262.0	225.6
Гэр хорооллоос	тн	16236.1	12588.1	788.5	503.0
ААНБ-аас	тн	7217.1	12876.2	279.4	514.5
Зам талбайгаас	тн	1000.9	31.4	65.3	31.6



МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО

Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 2017 оны 2-р улиралд 51.7 сая төгрөг болсон байна. 2-р улиралд интернэтийн үйлчилгээг байнгын хэрэглэгч 50 хүн, интернэт үйлчилгээний цэгээр 400 хүн үйлчлүүлсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 52.3 хувиар буурсан нь шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээ явуулдаг байсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 15. Мэдээлэл, холбооны салбарын үндсэн үзүүлэлт, 2-р улиралд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2017 он
Нийт орлого	мян.төг	108621.6	51750.0
Үүнээс: Хүн амаас орсон орлого	мян.төг	108621.6	51750.0
Интернэт үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчдийн тоо	хүн	417	400
Интернэтийн байнгын хэрэглэгч	хүн	55	50



НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Дүүргийн нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүд 2017 оны 2-р улиралд давхардсан тоогоор 804.2 мянган хүн тээвэрлэж, 460.0 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Өмнөх оны мөн үеэс үйлчилгээний орлого 18.1 хувиар буюу 101.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 16. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт, 2-р улиралд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2017 он
Нийт орлого	сая.төгрөг	561.7	460.0
Тээвэрлэсэн ачаа	мян.тонн	1.0	0.7
Ачаа эргэлт	мян.т.км	17.6	272
Зорчигчдын тоо	мян.хүн	1170.1	804.2
Зорчигч эргэлт	мян.хүн.км	3978.3	2734.4



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Оны эхний 6 сард Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 2921 байгууллагын нийт 110.9 мянга гаруй хүн хамрагдаж, шимтгэл төлсөн ба тэдгээрийн 53.0 мянга буюу 47.7 хувь нь ААНБ-ын, 9.8 мянга буюу 8.8 хувь нь төсвийн байгууллагын, 8.5 мянга буюу 7.7 хувь нь сайн дурын даатгуулагчид, 39.7 мянга буюу 35.8 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид байна.

Хүснэгт 17. Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлсэн байгууллага болон даатгуулагчийн тоо

Үзүүлэлт	2016.06	2017.06	Өсөлт	
			тоогоор	хувь
Нийт байгууллагын тоо	2734	2921	187	106.8
Аж ахуй нэгж байгууллагын тоо	2619	2803	184	107.0
Төсөвт байгууллагын тоо	115	118	3	102.6
Нийт даатгуулагчдын тоо	97737	110945	13208	113.5
ААНБ-ын даатгуулагчийн тоо	47258	52961	5703	112.1
Төсөвт байгууллагын даатгуулагчийн тоо	9250	9794	544	105.9
Сайн дурын даатгуулагчийн тоо	7727	8527	800	110.4
Эрүүл мэндийн даатгуулагчийн тоо	33502	39663	6161	118.4

Оны эхний 6 сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 63.4 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 9.5 тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн буюу 17.7 хувиар давж биелсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.3 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.


Хүснэгт 18. Нийгмийн даатгалын сангийн орлого, сан тус бүрээр, 2017 оны эхний 6 сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт %	
	2016.06	2017.06	2016.06	2017.06	2016	2017
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	31394.4	34166.0	34354.0	40215.1	109.4	117.7
Тэтгэмжийн сангийн орлого	3589.8	4235.4	3891.3	5149.0	108.4	121.6
ҮОМШӨ-ний даатгалын орлого	3592.6	3527.6	4487.7	4767.2	124.9	135.1
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	833.6	935.2	927.1	1049.0	111.2	112.2
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	10036.1	10943.6	10451.7	12172.6	104.1	111.2
Нийт	49446.5	53807.8	54111.8	63352.9	109.4	117.7


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 63.5 хувийг тэтгэврийн даатгалын санд, 8.1 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 7.5 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 1.7 хувийг ажилгүйдлийн даатгалын санд, 19.2 хувийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

Зураг14. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, хувиар



Зураг 15. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувиар



Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 13030 хүнд 28.0 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 2905 хүнд 4.1 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 779 хүнд 1.1 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1020 хүнд 3.3 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 5592 хүнд 815.8 сая төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 2012 хүнд 2.8 тэрбум төгрөгийг, 26 хүнд оршуулгын тэтгэмж 26 сая төгрөгийг тус тус олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 164 хүнд 441.5 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 17 хүнд 33.1 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 61 хүнд 41.1 сая төгрөгийг, ҮОМШЭ-ний сувилалд 12 хүнд 1.9 сая төгрөгийн тус тус олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авсан 1021 хүнд 2.0 тэрбум төгрөг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 63.6 хувийг тэтгэврийн, 7.7 хувийг тэтгэмжийн, 7.5 хувийг ҮОМШӨ-ний, 3.2 хувийг ажилгүйдлийн, 18.0 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Зураг16. Даатгалын сангийн орлого,



Зураг17. Нийгмийн даатгалын сангаас



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны эхний 6 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 13.8 хувийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжинд, 3.2 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжинд тус тус хуваарилсан байна.

Хүснэгт 19. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, оны эхний 6 сард, сая.төг

Үзүүлэлт	Дүн	Хүний тоо
Нийгмийн халамжийн сангийн орлого	7596.1	
1.Нийслэлийн төсвийн санхүүжилтийн орлого	5312.0	
а) Нийгмийн халамжийн сан	4044.3	
б) жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	1049.3	
в) ОНОТХаламжийн үйлчилгээ	86.8	
г) хүнс тэжээл хөтөлбөр	131.6	
2. Улсын төсвийн санхүүжилтийн орлого	2277.4	
а) алдарт эхийн одонгийн тусламж	975.0	
б) алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	240.0	
в) насны хишиг	1062.4	
3. Үйлчилгээний орлого	6.7	
а) хүүгийн орлого	4.5	
б) маягтын орлого		
в) бусад орлого	2.2	
Зарлагын нийт дүн	7550.1	33780
1. Нийгмийн халамжийн сан	4158.3	13391
2. Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	1045.1	6067
3. Алдарт эхийн одонгийн тусламж	957.3	7274
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	246.5	262
5. Хүнс тэжээл хөтөлбөр	132.4	393
6. ОНОТХ Үйлчилгээний зардал	1.8	2
7. Насны хишиг	1008.7	6391

Харин зарлагын 55.1 хувийг нийгмийн халамжийн санд буюу нийт 13391 хүнд, 7274 хүнд алдарт эхийн одонгийн тусламж, 262 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 6067 хүнд жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжийг тус тус зарцуулсан байна.



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ


Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2017 оны 6-р сарын байдлаар 737 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 950 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 49.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэ оны 6-р сард орон тооны цомхтголоор 53, байгууллага татан буугдсанаас 26, өөр газраас шилжиж ирсэн 7, сургууль төгссөн 28, цэргээс халагдсан 4, мэргэжлийн ажил олдохгүй 12, цалин багатайгаас 36, бусад шалтгаанаар 130 хүн ажилгүй болжээ.

Тайлант сард 52 хүн ажилд орсноос нөхөрлөл компанид 51, бусад газарт 1 хүн тус тус ажилд орсон байна.

Хүснэгт 20. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, жил бүрийн 6-р сарын эцэст

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2015.VI	2016.VI	2017.VI	2015.VI	2016.VI	2017.VI
Нийт ажилгүйчүүд	1885	1687	737	100.0	100.0	100.0
Үүнээс: Дээд боловсролтой	787	884	297	41.8	52.4	40.3
Тусгай дунд боловсролтой	111	88	40	5.9	5.2	5.4
Мэргэжлийн анхан шатны	112	75	21	5.9	4.5	2.9
Бүрэн дунд боловсролтой	771	613	347	40.9	36.4	47.1
Бүрэн бус дунд боловсролтой	79	21	23	4.2	1.2	3.1
Бага, боловсролгүй	25	6	9	1.3	0.3	1.2

Зураг 18. Ажилгүйчүүд насны бүлгээр, 6-р сарын эцэст



Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 40.0 хувь буюу 295 нь анх удаа ажил хайж байгаа бол 60.0 хувь буюу 442 нь урьд ямар нэг ажил хийж байжээ.

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 14.0 хувь буюу 103 нь 16-24 насны, 38.5 хувь буюу 284 нь 25-34 насны, 27.4 хувь буюу 202 нь 35-44 насны, 20.1 хувь буюу 148 нь 45-60 насны хүмүүс байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Дүүргийн хэмжээнд 2017 оны 6 сард нийт 1452 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 39.6 хувиар буюу 952 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 72.6 процидмилээр тус тус буурсан байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 30.5 хувийг салхин цэцэг, 8.8 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 4.6 хувийг тэмбүү, 22.7 хувийг гар хөл амны өвчин, 3.8 хувийг трихомониаз, 7.7 хувийг цусан суулга, 1.6 хувийг заг хүйтэн, 1.0 хувийг вируст гепатит, 0.9 хувийг гахайн хавдар, 18.4 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

Хүснэгт 21. Дүүрэгт гарсан халдварт өвчин, жил бүрийн 6 сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2017 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	Хувиар
Халдварт өвчин Үүнээс:	Бодит тоо	2404	1452	-952	-39.6
	10000 хүнд	166.2	93.6	-72.6	
Вируст гепатит	Бодит тоо	16	14	-2	-12.5
	10000 хүнд	1.1	0.9	-0.2	
Цусан суулга	Бодит тоо	67	112	45	1.7 дах
	10000 хүнд	4.6	7.2	2.6	
Улаан эсэргэнэ	Бодит тоо	58	130	72	2.2 дах
	10000 хүнд	4.0	8.4	4.4	
Сальмонеллэз	Бодит тоо	5	8	3	60.0
	10000 хүнд	0.3	0.5	0.2	
Салхин цэцэг	Бодит тоо	261	443	182	69.7
	10000 хүнд	18.0	28.5	10.5	
Гахайн хавдар	Бодит тоо	13	13	-	-
	10000 хүнд	0.9	0.8	-0.1	
Ёлом	Бодит тоо	4	4	-	-
	10000 хүнд	0.3	0.3	-	
Гар хөл, амны өвчин	Бодит тоо	308	329	21	6.8
	10000 хүнд	21.3	21.2	-0.1	
Тэмбүү	Бодит тоо	63	67	4	6.3
	10000 хүнд	4.4	4.3	-0.1	
Заг хүйтэн	Бодит тоо	21	23	2	9.5
	10000 хүнд	1.5	1.5	-	
Трихомониаз	Бодит тоо	64	55	-9	-14.1
	10000 хүнд	4.4	3.5	-0.9	
Шинээр илэрсэн сүрьеэ	Бодит тоо	169	128	-41	-24.2
	10000 хүнд	11.7	8.2	-3.5	
Мөөгөнцөр	Бодит тоо	5	3	-2	-40.0
	10000 хүнд	0.3	0.2	-0.1	
Улаан бурхан	Бодит тоо	1323	1	-1322	-99.9
	10000 хүнд	91.5	0.06	-91.4	
Бусад өвчлөл	Бодит тоо	27	122	95	4.5 дах
	10000 хүнд	1.9	7.9	6	

Зураг 19. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд



Зураг 20. Халдварт өвчнөөр өвчлөгчид



2017 оны 6 сард нялхсын эндэгдэл өмнөх оны мөн үеэс 5 хүүхдээр буюу 22.7 хувиар өсч, төрөхийн улмаас эндсэн эхийн тоо 1 эхээр, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 хүүхдээр буурсан байна.

Хүснэгт 22. Эх, хүүхдийн эндэгдэл, 6 сард


Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	$\frac{2016}{2017} \%$
Амаржсан эхийн тоо	2170	2189	2138	-2.3
Амьд төрсөн хүүхэд	2178	2196	2147	-2.2
Төрөхийн улмаас эндсэн эх	-	2	1	-50.0
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	23	22	27	22.7
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	2	5	2	-60.0



ГЭМТ ХЭРЭГ

Дүүргийн хэмжээнд 2017 оны 6 сард 728 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 16.4 хувиар буюу 143 хэргээр буурчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 66.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр дээгүүр байна.

Зураг 21. Гэмт хэргийн тоо




Нийт гэмт хэргийн 0.8 хувь буюу 6 нь бусдыг амиа хорлоход хүргэх, 28.4 хувь буюу 207 нь ББМБГУ, 30.8 хувь буюу 224 нь хулгайн хэрэг, 1.4 хувь буюу 10 нь хүчин, 0.4 хувь буюу 3 нь булаалт, 7.9 хувь буюу 58 хэрэг нь залилан мэхлэх гэмт хэрэг, 0.6 хувь буюу 4 нь дээрэм, 5.9 хувь буюу 43 хэрэг нь танхайрах, 7.6 хувь буюу 55 нь ТХХАБАЖЭ, 0.3 хувь буюу 2 нь хүнийг санаатай алах, 15.9 хувь буюу 116 нь бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

Хүснэгт 23. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр

Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2016.6	2017.6	$\frac{2017}{2016}$ %	Тоо
Бусдыг амиа хорлоход хүргэх	8	6	-25.0	-2
Хүчин	7	10	42.9	3
Дээрэм	19	4	-78.9	-15
Хулгай	230	224	-2.6	-6
Булаалт	5	3	-40.0	-2
Залилан	105	58	-44.8	-47
ББМБГУ	286	207	-27.6	-79
Танхайрах	45	43	-4.4	-2
Хүнийг санаатай алах	2	2	0	-
ТХХАБАЖЭ	53	55	3.8	2
Бусад	111	116	4.5	5
Бүгд	871	728	-16.4	-143

Нийт хулгайн хэрэг 224 байгаагаас 91.1 хувь нь иргэний өмчийн хулгай, 6.7 хувь нь халаасны хулгай, 0.9 хувь нь авто тээврийн хэрэгслийн хулгай, 1.3 хувь нь малын хулгайн хэрэг байна.

Зураг 22. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор



Хүснэгт 24. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор

Хороо	Гэмт хэрэг		Өөрчлөлт		Хүнийг санаатай алах	Бусдыг амиа хорлоход хүргэх	ББМБГУ	Хүчин	Хулгай	Үүнээс				Булаалт	Дээрэмдэх	Залилан мэхлэх	Танхайрах	ТХХАБАЖЭ	Бусад	Илрүүлэлт %
	2016.VI сар	2017.VI сар	Тоо	%						ИӨХ	Малын хулгай	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай							
1	56	30	-26	-46.4	0	0	9	1	8	6	0	0	2	1	1	7	1	1	1	58.8
2	104	82	-22	-21.2	0	1	21	0	28	26	0	2	0	0	0	7	6	6	13	67.4
3	116	84	-32	-27.6	0	0	23	1	19	19	0	0	0	0	0	5	7	11	18	56.4
4	73	74	1	1.4	1	1	15	0	38	30	1	0	7	0	0	3	2	4	10	65.9
5	19	13	-6	-31.6	0	0	2	1	6	5	0	0	1	0	0	0	0	0	4	71.4
6	10	24	14	140.0	0	0	9	1	6	6	0	0	0	0	0	0	2	2	4	77.7
7	24	10	-14	-58.3	0	1	1	0	2	2	0	0	0	0	0	1	2	1	2	85.7
8	31	28	-3	-9.7	0	0	14	0	9	9	0	0	0	0	0	0	2	1	2	76.9
9	33	23	-10	-30.3	0	0	7	1	5	5	0	0	0	0	0	0	4	2	4	75.0
10	70	82	12	17.1	0	2	28	0	21	21	0	0	0	1	0	4	5	8	13	80.0
11	98	72	-26	-26.5	0	1	20	0	23	21	0	0	2	0	0	14	0	2	12	58.5
12	23	28	5	21.7	0	0	8	0	12	11	1	0	0	0	0	0	2	2	4	73.3
13	13	19	6	46.2	0	0	6	3	7	6	1	0	0	0	0	0	0	3	0	55.5
14	21	21	0	0.0	0	0	3	2	8	8	0	0	0	0	1	0	1	3	3	27.2
15	129	101	-28	-21.7	1	0	26	0	21	19	0	0	2	1	1	15	7	8	21	66.7
16	51	37	-14	-27.5	0	0	15	0	11	10	0	0	1	0	1	2	2	1	5	88.2
Дүн	871	728	-143	-16.4	2	6	207	10	224	204	3	2	15	3	4	58	43	55	116	66.8

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2017 оны эхний 6 сарын байдлаар Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 1898 өргөдөл, гомдол ирсний 1151-ийг нь хуулийн дагуу хугацаанд нь хариу өгсөн, хугацаа болоогүй 747 өргөдөл байна.

Хүснэгт 25. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Д/д	Өргөдөл, гомдлын агуулга	Өргөдөл гомдлын тоо	Хэлбэр				Агуулга				Бусад байгууллагад шилжүүлсэн	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хүлээгдэж байгаа	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
			Амаар	Бичгээр	Утсаар	Цахим сүлжээгээр	Гомдол	Санал	Мэдэгдэл	Хүсэлт					
1	ТЗУХ	239		216		23	11			228		231		8	
2	СТСХ	1		-		1	1			-		-		1	
3	ТГХШХ	7		7		-				7		5		2	
4	НХХ	24		20		4	2			22		23		1	
5	ТНААХ	102		46		56	38	1		63		91		11	
6	ХХҮХ	41		32		9	6	1		34		32		9	
7	Цэргийн штаб	48		48		-				48		48		-	
8	Хууль зүйн тасаг	22		20		2	5		1	16		21		1	
ЗДТГ-ын дүн		484	-	389	-	95	63	2	1	418	-	451	-	33	-
1	ХХ	-													
2	ХХҮХ	134		132		2	1			133		134			
3	ӨГХА	782		712		70				782		68		714	
4	БоХ	103		41	6	56	48	12	6	37		103			
5	ОБХ	-													
6	Албан бус- НТБ төв	365	365							365		365			
7	БХ	30		30						30		30			
Дэргэдэх хэлтэс албадын дүн		1414	365	915	6	128	49	12	6	1347	-	700	-	714	-
Нийт дүн		1898	365	1304	6	223	112	14	7	1765	-	1151	-	747	-

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
Танилцуулгыг эрхлэн гаргасан: Ахлах мэргэжилтэн Ц.Энх-Оюун

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН
1212.mn

 Цахимаар:

www.1212.mn

Статистик мэдээллийн
нэгдсэн сан



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга
авч байхыг хүсвэл ЭНД ДАРЖ
бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail
хаягаа бүртгүүлснээр
статистикийн мэдээллийг
цаг алдалгүй тогтмол авч
байх болно.

SOCIAL NETWORK



[www.facebook.com/
Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)



[www.twitter.com/
statistic_mn](http://www.twitter.com/statistic_mn)



Ухаалаг гар утас, таблет
ашиглан статистик мэдээлэл
авах ezStat аппликейшн



Статистикийн хэвлэмэл
бүтээгдэхүүнийг унших
Монстат аппликейшн



Download on the
App Store

Google play



Утсаар:



Лавлах утас

1900-1212

QR код уншуулж татаж авна үү.

